



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/14-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Хүдэр сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер:	Б.Батмөнх
	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор :	Д.Чулуунцэцэг
	Утас: 70362442	Цахим хаяг: Chuluuntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	15-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	20-23
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



ХҮДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ЭНХТҮВШИН ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.23 № СЭА-2024/14-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүдэр сумын ТТЗ нь 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 1,594,433.2 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар давуулан биелүүлж, аймгийн төсөвт 1,190,983.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 2,264,500.0 мянган төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг баталснаас 2,020,379.7 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шалгалт үнэлгээний дүнгээр тус сумын 2023 оны үйл ажиллагааг 95.3 хувиар үнэлж аймгийн шилдэг сумын 3 дугаарт шалгарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,043,220.40	1,516,081.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,797,651.60	1,275,098.60
33	АВЛАГА	175,690.70	169,569.40
35	БАРАА МАТЕРИАЛ	69,878.10	71,413.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,291,236.60	5,389,115.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,291,236.60	5,389,115.10
39200	Биет хөрөнгө	3,265,478.80	5,363,833.00
39300	Биет бус хөрөнгө	25,757.70	25,282.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,334,457.00	6,905,196.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,789.40	3,370.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,789.40	3,370.40
41300	Өглөг	16,789.40	3,370.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,317,667.60	6,901,826.00
51	Засгийн газрын хувь оролцоо	6,317,667.60	6,901,826.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	287,430.80	287,430.80
51200	Хуримтлагдсан үр дүн	5,622,444.40	6,206,602.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,792.40	407,792.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,334,457.00	6,905,196.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,616,686.70	4,166,089.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,203,514.20	2,491,967.40
110	Орлогын албан татвар	378,248.40	498,369.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	378,248.40	520,090.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-21,720.80
113	Хөрөнгийн албан татвар	41,162.30	48,516.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,784,103.60	1,945,081.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	745,176.30	1,428,400.40
120	Нийтлэг татварын бус орлого	745,176.30	1,428,400.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,667,996.20	245,721.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,193,725.00	4,826,227.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,888,733.20	2,828,847.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,382,799.30	1,602,912.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,629.10	606,606.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,040.70	76,059.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,164.50	112,739.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,298.10	41,504.70
2105	Нормативт зардал	355.1	418.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,686.80	73,554.90
2107	Томилолт, зочны зардал	4,675.60	8,584.30

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,043,220.4	1,516,081.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	2,797,651.6	1,275,098.6
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	175,690.7	169,569.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	69,878.1	71,413.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,291,236.6	5,389,536.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,291,236.6	5,389,536.8
Биет хөрөнгө		3,265,478.8	5,363,833.0
Биет бус хөрөнгө	13	25,757.7	25,703.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,334,457.0	6,905,618.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,789.4	3,191.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	16,789.4	3,191.1
Өглөг	17а, 17б	16,789.4	3,191.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,317,667.6	6,902,426.9
Засгийн газрын хувь оролцоо		6,317,667.6	6,902,426.9
Засгийн газрын оруулсан капитал		287,430.8	287,430.8
Хуримтлагдсан үр дүн		5,622,444.4	6,207,203.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		407,792.4	407,792.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,334,457.0	6,905,618.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,358.00	85,813.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	485,591.50	597,631.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,505,933.90	1,225,935.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	304,991.90	1,997,379.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,422,961.70	-660,137.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,750,500.00	581,870.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,327,538.40	-1,242,008.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,660,539.00	8,660,539.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-15,333.10	-15,333.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,645,206.00	8,645,206.00
9	Тайлант үеийн үр дүн	-2,327,538.40	-2,327,538.40
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,317,667.60	6,317,667.60
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,317,667.60	6,317,667.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,317,667.60	6,317,667.60
19	Тайлант үеийн үр дүн	-1,241,008.30	-1,241,008.30
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,076,659.30	5,076,659.30

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,305,604.20	3,851,381.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,203,514.20	2,491,967.40
110	Орлогын албан татвар	378,248.40	498,369.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	378,248.40	520,090.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-21,720.80
113	Хөрөнгийн албан татвар	41,162.30	48,516.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,784,103.60	1,945,081.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	145,529.00	75,184.50
1181	Газрын төлбөр	287,309.10	364,534.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,351,265.40	1,505,361.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	423,554.80	852,298.20
120	Нийтлэг татварын бус орлого	423,554.80	852,298.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,678,535.10	507,115.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,701,266.50	2,689,174.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,701,266.50	2,689,174.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,174,729.90	1,456,986.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,973.10	605,796.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,040.70	76,059.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,164.50	56,004.60
2104	Хангамж, бараа материалын зардал	27,298.10	41,504.70
2105	Нормативт зардал	355.1	418.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,836.60	78,062.90
2107	Томилолт, зочны зардал	4,675.60	8,584.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,141.60	395,792.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,244.50	194,762.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,526,536.60	1,232,188.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,604,337.60	1,162,206.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,447,953.00	2,621,041.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,447,953.00	2,621,041.60
2200	Дотоод эх үүсвэрээр	1,447,953.00	2,621,041.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,447,953.00	-2,621,041.60
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-63,718.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	63,718.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,156,384.60	-1,522,553.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,641,266.90	2,797,651.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,797,651.60	1,275,098.60

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,658,924.10	4,165,546.97	493,377.1	89.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,544,264.70	1,517,887.68	26,377.02	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,509,295.60	1,482,935.88	26,359.72	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,054.60	605,796.36	258.24	100.0
210101	Үндсэн цалин	293,080.40	356,392.61	-63,312.21	121.6
210102	Нэмэгдэл	218,794.70	214,421.70	4,373.00	98.0
210104	Урамшуулал	39,282.60	25,460.39	13,822.21	64.8
210105	Гэрээт ажлын хөлс	54,896.90	9,521.66	45,375.24	17.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,399.70	76,059.65	340.05	99.6
210201	Тэтгэврийн даатгал	52,169.80	51,921.25	248.55	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,020.40	5,998.10	22.30	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,069.40	5,047.21	22.19	99.6

210204	Ажилгүйдлийн даатгал	1,204.00	1,201.79	2.21	99.8
210205	Эрүүл мэндийн даатгал	11,936.10	11,891.30	44.80	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,361.60	352,945.53	4,416.07	98.8
210301	Гэрэл, цахилгаан	30,461.20	24,664.46	5,796.74	81.0
210302	Түлш, халаалт	293,733.80	295,115.47	-1,381.67	100.5
210303	Цэвэр, бохир ус	33,166.60	33,165.60	1.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,797.00	40,277.67	519.33	98.7
210401	Бичиг хэрэг	4,313.80	4,032.30	281.50	93.5
210402	Тээвэр, шатахуун	26,725.50	28,793.54	-2,068.04	107.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,628.10	2,265.27	362.83	86.2
210404	Ном, хэвлэл	4,000.00	2,089.80	1,910.20	52.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23.20	0	23.2	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,106.40	3,096.76	9.64	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,177.40	119,153.35	24.05	100.0
210604	Урсгал засвар	84,677.60	84,653.55	24.05	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,252.80	8,584.30	1,668.50	83.7
210702	Дотоод албан томилолт	10,252.80	8,584.30	1,668.50	83.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,337.20	88,063.44	10,273.76	89.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,689.30	85,960.80	8,728.50	90.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	347.80	0	347.8	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	715.60	258.03	457.58	36.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	405.40	88.36	317.04	21.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200.10	81.70	118.40	40.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	670.90	628.80	42.10	93.7
210807	Газрын төлбөр	400.20	199.76	200.44	49.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	907.90	846.00	61.90	93.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,496.90	191,637.18	8,859.72	95.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,089.70	191,034.58	8,055.12	96.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,407.20	602.60	804.60	42.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,969.10	34,951.80	17.30	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,969.10	34,951.80	17.30	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,788.00	3,770.70	17.30	99.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,264,500.00	2,583,941.29	-319,441.29	114.1
220001	Барилга байгууламж	2,018,000.00	1,904,694.10	113,305.90	94.4
223001	Бусад хөрөнгө	246,500.00	679,247.19	-432,747.19	275.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	82,000.00	63,718.00	18282	77.7
230001	Эргэж төлөгдөх зээл	82,000.00	63,718.00	18,282.00	77.7

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,890,764.70	4,119,337.31	-228,572.61	105.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,807,144.70	4,038,895.41	-231750.713	106.1
320001	Орон нутгийн төсвөөс	3,807,144.70	3,541,936.01	265,208.687	93.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	496,959.40	496,959.40		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	83,620.00	80,441.89	3178.106	96.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,620.00	77,878.23	0.0	187.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	2,563.67	0.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	42,000.00	0	0.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	286,414.75		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	240,205.08		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

<i>/мянган төгрөгөөр/</i>		
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,153.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,904.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,902.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,227.0
210401	Бичиг хэрэг	600.0
210402	Тээвэр, шатахуун	627.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,125.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,125.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,248.4
2200	Дотоод эх үүсвэрээр	6,248.4
220001	Барилга байгууламж	6,246.4
223001	Бусад хөрөнгө	2.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,153.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,153.2
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,798.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	979.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,375.4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Хүдэр сумын ТТЗ гэх/ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “*Өрхийн орлогоос-Хүдрийн хөгжил*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/450 дугаар тушаалаар “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журмыг шинэчлэн баталсан гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

Хүдэр сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт тавьж ажилладаг байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ЗДТГ, ИТХ, ОНХС, ОНХО-ын 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгээгүй зэрэг зөрчлийг илрүүлж зөвлөмж өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүдэр сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 6,905,196.3 мянган төгрөг болж өмнөх оноос 570,739.4 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,797,651.6	1,275,098.6	-1,522,553.0
Авлага	175,690.7	169,569.3	-6,121.4
Бараа материал	69,878.1	71,413.3	1,535.2
Үндсэн хөрөнгө	3,291,236.5	5,389,115.1	2,097,878.6
Нийт хөрөнгө	6,334,456.9	6,905,196.3	570,739.4
Өр төлбөр	16,789.3	3,370.3	-13,419.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,317,667.6	6,901,826.0	584,158.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,334,456.9	6,905,196.3	570,739.4

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,275,098.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,522,553.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө			
Төрийн сангийн харилцах	2,797,651.6	1,275,098.6	-1,522,553.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах			
Дүн	2,797,651.6	1,275,098.6	-1,522,553.0

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 958,989.7 мянган төгрөг, ОНХС-ийн 224,300.2 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн 75,903.7 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн 15,904.8 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 169,569.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,121.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9,813.1	2,752.3	-7060.8
Зээлийн хүүгийн авлага	7,752.1	5,441.2	-2311.0
Татаас санхүүжилтийн авлага	4,288.5		-4288.5
Байгууллагаас авах авлага	25,892.0	3,297.1	-22,594.9
Хувь хүмүүсээс авах авлага			
Хувь хүмүүст олгосон зээл	127,945.0	158,078.8	30,133.8
Дүн	175,690.7	169,569.4	-6,121.4

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ЗДТГ-ын 4,722.1 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үндсэн зээлийн болон хүүгийн эргэн төлөлтийн 163,520.0 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын 1,327.3 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 96,4 хувь буюу 163,520,0 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 71,413.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,535.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	24,223.6	23,983.6	-240.0
Аж ахуйн материал	13,824.5	12,454.7	-1,369.8

Бусад хангамжийн материал	31,170.1	34,975.0	3,804.9
Мал амьтад	660.0	0	-660.0
Дүн	69,878.2	71,413.3	1,535.1

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,535.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,296,398.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 2,294,863,2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 6,799,013.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,450,031.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,322,300.7	6,772,332.1	2,450,031.4
Барилга, байгууламж, орон сууц	1,097,838.1	2,932,731.7	1,834,893.6
Авто-тээврийн хэрэгсэл	621,966.1	589,966.1	-32,000.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	153,100.7	175,282.6	22,181.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	42,725.8	49,295.7	6,569.9
Зам гүүрний байгууламж	1,360,318.3	1,856,986.0	496,667.7
Дуусаагүй барилга	27,431.3	27,431.3	-
Түүх соёлын дурсгалт зүйл	250.0	250.0	-
Бусад үндсэн хөрөнгө	1,018,670.4	1,140,388.7	
Биет бус хөрөнгө	26,681.0	26,681.0	-
Программ хангамж	1,379.0	1,379.0	-
Бусад биет бус хөрөнгө	25,302.0	25,302.0	-
Дүн	4,348,981.7	6,799,013.1	2,450,031.4

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 2,450,031.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ОНХО-аар хэрэгжсэн 1,834,893.8 мянган төгрөгийн спорт заал, 23,000.0 мянган төгрөгийн автомашин, 31,731.3 мянган төгрөгийн камер, гүүр, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28,751.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, архивын нягтруулсан шүүгээ, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн 586,654.5 мянган төгрөгийн хатуу хучилттай зам, мал угаалгын ванн, биотермийн нүх, ундны усны шүүлтүүр зэргийг орлогоор бүртгэж, аймгийн ИТХ-ын 2023 оны 128 дугаар тогтоолоор 55,000.0 төгрөгийн авто машиныг акталсантай холбоотой байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,370.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,419.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг			
Бараа үйлчилгээний зардлын өглөг	16,789.3	3,370.3	-13,419.0
Байгууллагад төлөх өглөг			
Дүн	16,789.3	3,370.3	-13,419.0

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ЗДТГ, Соёлын төвийн тогтмол зардлын 3,370.3 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,901,826.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 584,158.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287,430.8	287,430.8	0.0
Хуримтлагдсан үр дүн	5,622,444.4	6,206,602.9	584,158.5
Өмнөх үеийн үр дүн	7,949,982.7	5,622,444.4	2,327,538.3
Тайлант үеийн үр дүн	-2,327,538.4	584,158.4	-1,743,380.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,792.4	407,792.4	0.0
Дүн	6,317,667.6	6,901,826.1	584,158.5

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 584,158,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хүдэр сумын ИТХ-ын “2023 оны тодотгосон төсвийг батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 142 дугаар тогтоолоор татварын орлогыг 2,318,486.4 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 275,000.0 мянган төгрөгөөр нийт орон нутгийн орлогыг 2,593,486.4 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,187,920.0 СЭА-2024/14-НА-СТА-ТТЗ

мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **1,594,433.2** мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

<i>/мянган төгрөг/</i>					
№	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татварын орлого	2,318,486.4	2,491,967.5	101,518.9	107.5
2	Хүн амын орлогын албан татвар	341,280.4	498,369.9	157,089.5	146.0
3	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	336,000.4	487,293.3	151,292.9	145.0
4	Үйл ажиллагааны орлого	10,000.0	7,175.7	-2,824.3	71.7
5	Хөрөнгө борлуулсны орлого	280.0	7,448.0	7,168.0	26.6
6	Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	15,000.0	18,173.7	3,173.7	121.1
7	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-21,720.8	-21,720.8	-1,720.8	108.6
8	Хөрөнгийн албан татвар	49,250.0	48,516.4	-733.6	98.5
9	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,000.0	9,843.5	-156.5	98.4
10	Бууны албан татвар	2,250.0	2,970.0	720.0	132.0
11	Малд ноогдуулах албан татвар	37,000.0	35,702.9	-1,297.1	96.4
12	Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	40,800.0	75,184.5	34,384.5	184.2
13	Улсын тэмдэгтийн хураамж	30,000.0	72,228.8	42,228.8	240.7
14	Хог хаягдлын хураамжийн орлого	10,000.0	680.0	-9,320.0	284.4
15	ТТАМАТөлбөр	800.0	2,275.7	1,475.7	284.4
16	Газрын төлбөр	300,940.4	364,534.8	63,594.4	121.1
17	Газрын төлбөр	300,940.4	364,534.8	63,594.4	121.1
18	Байгалийн нөөц ашигласны төлбөр	586,216.0	1,505,361.9	919,145.9	256.7
19	Ойн нөөц ашигласны төлбөр	581,266.0	1,500,003.6	918,737.6	258.0
20	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,350.0	1,627.0	277.0	120.5
21	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	3,600.0	3,731.3	-131.3	103.6
22	Татварын бус бусад орлого	275,000.0	695,952.5	420,952.5	253.0
23	Нэр заагаагүй бусад орлого	230,000.0	671,488.8	441,488.8	291.9
24	Хүү, торгуулийн орлого	45,000.0	24,463.7	-20,536.3	54.3
	Нийт орлогын дүн	2,593,486.4	3,187,920.0	1,594,433.2	122.9

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хүн амын орлогын албан татвар 157,089.5 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 42,228.8 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 63,594.4 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 918,737.6 мянган төгрөгөөр татварын бус бусад орлого 420,952.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын гүйцэтгэлээр хог хаягдлын хураамжийн орлого, хүү, торгуулийн орлого зэрэг орлогууд тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдсэн. 2023 онд Дархан төмөрлөгийн үйлдвэрийн хоол үйлдвэрлэлийн салбар нэгж нэмэгдэж ХХОАТ төлөгчийн бааз нэмэгдсэн.
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** Хуш модны самар бэлтгэх хэмжээ нэмэгдсэнээс тэмдэгтийн хураамжийн орлого нэмэгдсэн байна.
- ✓ **Байгалийн нөөц ашигласны төлбөр:** БОЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Ойн ангитай хамтран самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар ААН-үүдтэй нэмж гэрээ байгуулж, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдсэн,
- ✓ **Нэр заагаагүй бусад орлого:** Хуш модны самар бэлтгэх журамд өөрчлөлт орж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нөөцийн нэмэлт зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгож, дэнчингийн орлого төвлөрснөөс шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- ✓ **Хог хаягдлын хураамжийн орлого:** Сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын хураамжийн орлогыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулаагүйгээс шалтгаалсан байна.
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Орлогын төлөвлөгөөг хэт өндөр төлөвлөснөөс шалтгаалж тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,812,907.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,163,486.4 мянган төгрөг, ерөнхий орлогын оны эхний үлдэгдлээс 2,026,119.9 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 234,200.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 457,454.5 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 83,620.0 мянган төгрөг зэрэг нийт 3,964,880.9 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, аймгийн төсөвт 190,983.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн **3,773,897.4** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 128 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,593,486.4 мянган төгрөгөөр, урьд оны ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 2,404,641.8 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 234,200.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 533,959.4 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 83,620.0 мянган төгрөг зэрэг нийт 4,849,907.6 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, аймгийн төсөвт 1,190,983.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн **4,658,924.1** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 142 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын татварын болон татварын бус орлогыг 2,593,486.4 мянган төгрөгөөр, урьд оны ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 2,404,641.8 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 234,200.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 533,959.4 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 83,620.0 мянган төгрөг зэрэг нийт **5,849,907.6** мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, аймгийн төсөвт 1,190,983.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн **4,658,924.1** мянган төгрөгийг зарцуулахаар эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 3,511,486.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 527,409.8 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 77,878.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,563.7 мянган төгрөг зэрэг нийт **4,119,337.3** мянган төгрөгийн санхүүжилт олгож оны эхний дансны үлдэгдлээс 46,209.6 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл **4,165,546.9** мянган төгрөг буюу **89.4** хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин, НДШ-ийн зардал 598.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,416.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,668.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 10,273.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8,859.7 мянган төгрөгөөр, тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 11 төсөл, арга хэмжээнд 2,264,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 2,020,379.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 244,120.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 8 төсөл, арга хэмжээнд 768,159.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 563,561.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 204,597.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 3 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 1,363.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1,291.8 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулга, уулзалтын зардалд 600.0 мянган төгрөг, тендерийн орлогоор 650.0 мянган төгрөг, өмнөх оны дансны үлдэгдлээс 6,248.4 мянган төгрөг зэрэг нийт **10,153.3** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс мал тооллогын зардалд 1,404.9 мянган төгрөг, хүүхдийн чуулганы болон хамтарсан багийн зардалд 900.0 мянган төгрөг, гэрэлтүүлгийн хяналтын зардалд 6,248.4 мянган төгрөг, ахмадын арга хэмжээний зардалд 1,000.0 мянган төгрөг, тендерийн баримт бичиг боловсруулах зардалд 600.0 мянган төгрөг зэрэг нийт **10,153.3** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 8.

/мянган төгрөг/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	3	712,054.5	2	212,054.5	1	500,000.0
Сумын ОНХО	5	2,173,500.0			5	2,173,500.0

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн ХА ажиллагааны төлөвлөгөө тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүдэр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийг холбогдох хууль эрхийн актын хүрээнд үнэн зөв төлөвлөж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/94 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зарлагын 4,193,725.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 41,937.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Автомашинуудад цэнхэр дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	151	27	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	180	2	-
3	Засаг даргын Тамгын газар	182	179	3	-
	Нийт дүн	542	510	32	-

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 178 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ЗДТГ-ын урсгал засварын зардлаас хэрэгжсэн сумын төвийн доторх сайжруулсан зам засварын 39,600.0 мянган төгрөгийн өртөгтэй ажлыг гүйцэтгэхдээ харьцуулалтын аргаас зайлсхийж төсөвт өртгийг 2 хуваан, Нутгийн зам трейд ХХК, ЦБТ бумтан ХХК-иар шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 8.6 дахь “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэнд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ижил төстэй төсөл арга хэмжээг хувааж шууд худалдан авах аргаар гүйцэтгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 24,371.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр НИК компаниас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАУХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,974.5 мянган төгрөгийн актын төлбөрийг бүрэн барагдуулж, 33,603.4 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 2,713.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	6,974.5	1	6,974.5	100.0
Албан шаардлага	6	33,603.4	6	33,603.4	100.0
Зөвлөмж	3	2,713.0	3	2,713.0	100.0
Нийт дүн	11	43,290.9	8	43,290.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 2011-2019 онуудад олгогдсон, хугацаа хэтэрсэн, /зээлийн үлдэгдлийг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандсан, эвлэрлийн гэрээ байгуулсан, зээл төлүүлэх мэдэгдэх хуудсыг өгч ажиллаж байгаа хэдий ч/ зээлийн үлдэгдлийг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна. Уг зээлийг барагдуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангасан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **1,923,336.2** мянган төгрөгийн алдаа илэрч 1,849,004.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 57,889.8 мянган төгрөгийн алдааг залруулах зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

Залруулсан алдаа / 1,849.004.9 мянган төгрөг /

1. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцоогүйгээс нийт 9,511.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн байна. Үүнд:

- ИТХ нь 784.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 8,727.1 мянган төгрөгийн гэх мэт.

2. ИТХ нь бичиг хэргийн материалын дансанд бүртгэх 4,600.0 мянган төгрөгийн материалыг хангамжийн материалын дансанд бүртгэж, тайлагнасан байна.

3. ЗДТГ нь тайлант онд ОНХО-аар хэрэгжсэн 1,834,893.8 мянган төгрөгийн өртөг бүхий Спорт заалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнаагүй байна.

Залруулаагүй алдаа: ЗДТГ / 74,331.8 мянган төгрөг /

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх 17,931.3 мянган төгрөгийн зам гүүр, 9,500.0 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлгийг дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэж тайлагнасан,
- ОНХО-ын эх үүсвэрээр худалдан авсан 46,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий авто машиныг үндсэн хөрөнгөд орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн бүртгэлийг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **54,409.0** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **34,609.2** мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, **19,800.0** мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ыг илүү шилжүүлэн нийт **4,295.2** мянган төгрөгийн авлага үүсгэсэн боловч бүртгэл тайланд тусгаагүй байна. Үүнд:

- ИТХ нь НДШ-д 683.0 мянган төгрөг, ХХОАТ-т 1,824.5. мянган төгрөгийн,
- ЗДТГ нь ХХОАТ-т 1,787.7 мянган төгрөгийн гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.”, 14.4.2: “бүх хөрөнгө хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, НДШ, ХХОАТ-ын авлагыг барагдуулах, цаашид төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. ИТХ нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гүйцэтгэлийн тайлан, үр дүнг тооцсон илтгэх хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр “Нутгийн удирдлагын холбоо” ТББ-тай хамтран сумын ИТХ-ын 21 төлөөлөгч, ИТХ-ын нарийн бичгийн дарга зэрэг нийт 22 хүнийг БНХАУ-ын Эрээн-Жининь-Хөх хотод зохиогдсон сургалт, туршлага судлах арга хэмжээнд оролцуулан нийт **20,214.0** мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 дахь “Үр ашигтай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажил гүйлгээг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

3. Холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэр, гүйцэтгэлийн тайлан, үнийн тооцоо судалгаа зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **10,100.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- ИТХ нь хуралдааны зардлын 1,601.8 мянган төгрөг, ГХУС арга хэмжээний зардлын 2,498.2 мянган төгрөг,
- ТТЗ-ийн ОНХС нь шатахууны зардлын 2,000.0 мянган төгрөг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс тус сумын 12 жилийн дунд сургуулийн багш Н.Уранчимэг, ЭМТ-ийн их эмч О.Батчимэг нарт олгосон хөдөө орон нутагт шилжин суурьшиж ажилласны тэтгэмж 4,000.0 мянган төгрөг гэх мэт.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын чиг үүрэгт үл хамаарах гудамжны гэрэлтүүлгийн урсгал засварын **19,800.0** мянган төгрөгийн төсвийг сумын ЗДТГ-ын төсөвт тусган төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”: 5.1.2: “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зардлыг холбогдох байгууллага арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар бодитой, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх,

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	4	1,917,952.2	2	1,843,620.9	2	74,331.3	3	1,843,620.9	2	74,331.3	2	74,331.3
ИТХ	2	5,384.0	2	5,384.0			2	5,384.0				
Дүн	6	1,923,336.2	4	1,849,004.9	2	74,331.3	4	1,849,004.9	2	74,331.3	2	74,331.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүдэр ТТЗ	6	54,409.0			5	34,609.2	1	19,800.0				
Дүн	6	54,409.0			5	34,609.2	1	19,800.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ нь шилэн дансны 27 мэдээллийг хугацаа хоцроосон	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг баримтлаагүй	1	24,371.2					1	24,371.2
Төсөвт өртгийг 2 хувааж гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан	1	39,600.0					1	39,600.0
Дүн	2	63,971.2					2	63,971.2
Нийт дүн	3	63,971.2					3	63,971.2